



ҮНЭТ ЦААСНЫ СУДАЛГАА

MSE:CUMN 

2025-08-25



ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Компанийн нэр	“ПРЕМИУМ НЭКСУС” ХК		
Тэмдэг	MSE: CUMN		
Агуулагдах индекс	МХБ Топ 20 Индекс		
Үүсгэн байгуулагдсан огноо	2015 он (Сэнтрал Экспресс ХХК)		
Нээлттэй болсон огноо	2021 он 11-р сар (МХБ)		
Бизнесийн чиглэл	Худалдаа		
Үйл ажиллагааны чиглэл	C10 Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл		
Нийт гаргасан хувьцаа	1,114,252,034.0	Ш	
IPO-н нэрлэсэн ханш	208.0	MNT	
Хаалтын ханш (2025-08-22)	200.0	MNT	▲3.1% (52W)
Зах зээлийн үнэлгээ	222,850,406,800.0	MNT	#9/20 (Top20)
Өдрийн арилжааны дүн	10,278,499.2	MNT	(52W Дундаж)

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж





КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Төлөөлөн
удирдах зөвлөл



Гари Стефен Биондо
ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн

Гишүүд Хараат бус



Гүйцэтгэх
захирал



А. Ганхуяг
Гүйцэтгэх захирал

Удирдлагын
баг



Г. Чинзориг
Гүйцэтгэх захирлын орлогч



Г. Бат-Эрдэнэ
Санхүү хариуцсан захирал



Н. Энхболд
Портфолио хариуцсан захирал



С. Дашдорж
Коммерс хариуцсан захирал



Ч. Мөнхчимэг
Хүний нөөц хариуцсан захирал

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж,
Премиум Нэксус ХК-н цахим хуудас болон 2025Н1 санхүү үйл ажиллагааны тайлан

Хувьцаа эзэмшигчид (2025-06-10)



27.4%

А. Ганхуяг



18.6%

А. Ганболд



17.2%

Премиум Групп ХХК



8.3%

BGF Retail Co., Ltd.



7.9%

Ц. Баяржаргал



2.0%

Г. Бат-Эрдэнэ



18.6%

Олон нийт (9,300) болон бусад


Охин компаниуд (2025-07-31)



Премиум Нэксус ХК



Чингис Шар Айраг
ХХК




Сэнтрал Коммерс
ХХК




Премиум Коммерс
ХХК




Сэнтрал Фүүдс
ХХК



Стора Централ
ХХК



Сэнтрал Кофе
Рөүстинг ХХК




Премиум Юнайтэд
ХХК





КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Бизнесийн зураглал




Эх сурвалж: Премиум Нэксус ХК-н 2025H1 санхүү үйл ажиллагааны тайлан, 2024 оны үйл ажиллагааны тайлан





ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД




Эх сурвалж: Премиум Нэксус ХК-н 2024 оны үйл ажиллагааны тайлан, цахим хуудас






ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА


2025 оны 1-р хагас жилийн байдлаар




БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, их наяд MNT



CU-н БО БА ЗЗ-Д ЭЗЛЭХ ХУВЬ, тэрбум MNT



CU БОЛОН GS25 КОНВИНИЕНС ДЭЛГҮҮРИЙН ТОО, 2025 оны 1-р хагас жил



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОП ТОГЛОГЧ

2025 оны эхний хагас жилийн байдлаар худалдааны салбар нь улсын нийт нэрлэсэн ДНБ-ний 7.8%-ийг бүрдүүлжээ. Борлуулалтын орлогын хэмжээгээр авч үзвэл, 2025 оны 6 дугаар сарын байдлаар худалдааны салбар нийтдээ 30.8 их наяд төгрөгийн борлуулалт хийснээс, дийлэнх буюу 17.4 их наяд төгрөг нь жижиглэн худалдаанаас бүрдсэн байна. Энэхүү орлогыг нийтдээ 7,711 аж ахуйн нэгж, байгууллага бий болгожээ.

“Премиум Нэксус” ХК-ийн хувьд, 2025 оны эхний хагас жилд түүний нийт борлуулалтын орлого 362 тэрбум төгрөгт хүрч, жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалтын орлогын 2.1%-ийг эзэлж байна. Тус компанийн зах зээлд эзлэх хувь сүүлийн дөрвөн жил дараалан өссөөр ирсэн бөгөөд 2021 онд анх 0.5%-ийг эзэлж байжээ.

Дэлгүүрийн тооны хувьд авч үзвэл, 2025 оны хагас жилийн байдлаар CU сүлжээ 495 дэлгүүртэй болж, зах зээлд тэргүүлэх байр сууриа хадгалсаар байна. Харин GS25 сүлжээ 280 дэлгүүртэйгээр хоёрдугаарт бичигдэж байгаа нь конвениенс дэлгүүрийн зах зээлд CU чухал тоглогч гэдгийг харуулж байна.





ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

НЭГ КОНВИНИЕНС ДЭЛГҮҮРТ НОГДОХ ХҮНИЙ ТОО,
2024 он, Зүүн Өмнөд Азийн улсууд

Улсууд	Нэг дэлгүүрт ногдох хүн ам	Дэлгүүрийн тоо	ДНБ (сая USD)
Өмнөд Солонгос	1,130	46,000	1,875,208
Тайвань	1,800	13,000	797,035
Япон	2,230	56,000	4,026,318
Австрали	3,571	7,000	1,794,556
Тайланд	3,580	20,000	527,173
БНХАУ	4,700	300,000	18,734,628
Жигнэсэн Дундаж	4,831		
Монгол	4,913	722*	23,595
Хонг Конг	5,700	1,300	406,912
Малайз	11,190	3,000	422,817
Индонез	13,700	20,000	1,396,250
Вьетнам	14,280	7,000	476,300
Филиппин	16,280	7,000	461,301

* - Тайлбар: Монгол улсын конвиниенс дэлгүүрийг
тоолохдоо CU болон GS25-н дэлгүүрүүдийг тоолсон болно.

5,000 ХҮН ТУТАМД НЭГ ДЭЛГҮҮР

2024 оны байдлаар Зүүн Өмнөд Азийн бүс нутагт нэг конвиниенс дэлгүүрт дунджаар 4,831 хүн ногдож байгаа бол өрсөлдөөн эрс өндөртэй Өмнөд Солонгос, Япон, Тайвань зэрэг улсуудад энэ үзүүлэлт 1,130–2,230 хүн тутамд нэг дэлгүүр ногдож байна. Харин хүн ам олон боловч эдийн засгийн хэмжээ харьцангуй бага Филиппин, Вьетнам зэрэг улсад дунджаар 15,264 хүн тутамд нэг дэлгүүр ногдож байгаа юм.

Монгол Улсын хувьд CU болон GS25 конвиниенс дэлгүүрүүдийн нийт тоонд үндэслэн тооцоход, улсын хэмжээнд 4,913 хүн тутамд нэг дэлгүүр ногдож байгаа нь дэлхийн дундажтай тун ойролцоо үзүүлэлт болж байна.

Цаашдаа Өмнөх Солонгос, Япон зэрэг конвиниенс дэлгүүр сайн хөгжсөн зах зээлийн түвшинд нэг дэлгүүрт ногдох хүн амын тоог 2,000-д хүрэх замаар тэлэх боломж байна.






САНХҮҮ ҮР ДҮН


БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО БА ДЭЛГҮҮРИЙН ТОО тэрбум MNT

Дундаж өсөлт: **96.9%**




НИЙТ ХӨРӨНГӨ тэрбум MNT

Дундаж өсөлт: **56.0%**




ЦЭВЭР АШИГ тэрбум MNT

Дундаж өсөлт: **25.3%**



ЭЗДИЙН ӨМЧ тэрбум MNT

Дундаж өсөлт: **238.4%**



* - Тайлбар: 2024 оны 2-р хагас жилээс нэг удаагийн шинж чанартай 19.5 тэрбум төгрөгийн тохиролцоот худалдан авалтын олзыг хасаж тооцов.

“Премиум Нэксус” ХК-ийн борлуулалтын орлого 2020 онд 45.3 тэрбум төгрөг байсан бол 2024 оны эцэст 598 тэрбум төгрөгт хүрч, жилд дунджаар 96.9%-иар өссөн байна. Энэхүү эрчимтэй өсөлт нь дэлгүүрийн тоо тогтмол нэмэгдсэнтэй шууд холбоотой бөгөөд сүүлийн жилүүдэд фрайнчайзын орлого нэмэгдсэн нь мөн чухал нөлөө үзүүлжээ. 2024 оны жилийн эцсийн тайланд дурдсанаар нийт борлуулалтын орлогын 94.7%-ийг дэлгүүрийн борлуулалт бүрдүүлж байна.

2024 оны 1-р сард компанийн зүгээс “Чингис Шар Айраг” ХХК болон “Стора Централ” ХХК зэрэг хэд хэдэн компаниудыг нэгтгэн авсан нь борлуулалтын орлогод эергээр нөлөөлсөн чухал хүчин зүйлсийн нэг болсон. Энэ нэгтгэлийн үр дүнд компанийн нийт хөрөнгө мэдэгдэхүйц нэмэгдэж, 2024 онд нийт хөрөнгө цэвэр дүнгээр 120 тэрбум төгрөгөөр буюу 62.2%-иар өссөн байна. Жишээ нь: Бизнесийн нэгдэлтэй холбоотойгоор биет бус хөрөнгө 32 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Улмаар нийт хөрөнгө 2025 онд 377.8 тэрбум төгрөгт хүрч, сүүлийн таван жилд дунджаар 56%-ийн өсөлт үзүүлжээ.

Салбарын тоог идэвхтэй нэмэгдүүлэхтэй зэрэгцэн хөрөнгө оруулалтын зардал өндөр гарч байсан жилүүдэд компанийн цэвэр ашиг алдагдалтай байлаа. Тухайлбал, 2020 онд -15.7 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан бол 2023 онд энэ дүн -32.7 тэрбум төгрөг болж алдагдал нэмэгдсэн байна. Харин 2024 онд цэвэр ашиг эерэг болж эхэлсэн бөгөөд энэ нь бизнесийн нэгтгэл болон борлуулалтын орлогын өсөлттэй холбоотой юм. Мөн түүнчлэн борлуулалтын орлогод эзлэх борлуулсан бүтээгдэхүүний өртгийн (ББӨ) харьцаа 2023 онд 100.7% байсан бөгөөд 2024 онд 86.6% болж сайжирсан нь нийт ашиг өсөх чухал хүчин зүйл болжээ. ББӨ буурахад бараа материалын хорогдол буурсан нь нөлөө үзүүлсэн байна. Нэг удаагийн шинж чанартай 19.5 тэрбум төгрөгийн тохиролцоот худалдан авалтын олзыг хасаж тооцвол, 2024 оны цэвэр ашиг 27.9 тэрбум төгрөгт хүрсэн бол ашигт ажиллагаа үргэлжилсээр 2025 оны эхний хагас жилийн байдлаар 15.7 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байна.

Ийнхүү цэвэр ашиг алдагдалтай жилүүдэд хуримтлагдсан алдагдал нэмэгдсэнээр эздийн өмч 2023 онд -14.3 тэрбум төгрөгт хүрсэн бол 2024 оноос цэвэр ашиг нэмэгдэж, мөн бизнесийн нэгтгэл хийсэнтэй холбоотойгоор эздийн өмч нэг жилийн дотор 117 тэрбум төгрөгөөр өсжээ. Үүнээс 29.5 тэрбум төгрөг нь хувьцаат капиталын өсөлт, 31.9 тэрбум төгрөг нь нэмж төлөгдсөн капиталын өсөлт, үлдсэн нь цэвэр ашгийн өсөлт байна. 2025 оны хагас жилийн байдлаар эздийн өмч 118.5 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй гарлаа.






СУУРЬ ТААМАГЛАЛ


БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО
цэвэр дүнгээр, хагас жилээр, тэрбум MNT




МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО
мянган хүн



ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОО
цэвэр дүнгээр, сая удаа, давхардсан тоогоор



СУ-Н НЭГ ДЭЛГҮҮРТ САРД ҮЙЛЧЛҮҮЛЖ БҮЙ НИЙТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОО
сарын дундаж




СУ-Н ДЭЛГҮҮРИЙН ТОО
өсөн нэмэгдэх




БҮТЭЭМЖИЙН СТРАТЕГИ



НЭГ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЗАРЦУУЛАЛТ
цэвэр дүнгээр, MNT/хүн



СУ-Н НЭГ ДЭЛГҮҮРТ НООГДОХ ХҮН



ТЭЛЭЛТИЙН СТРАТЕГИ



Эх сурвалж: Тооцоолол




СУУРЬ ТААМАГЛАЛ


ТЭЛЭЛТИЙН СТРАТЕГИ

Тэлэлтийн стратеги нь дэлгүүрийн тоог нэмэг замаар CU-н нэг дэлгүүрт ногдох хүн амын тоог бууруулна. Ирээдүйн таамаглалыг боловсруулахдаа зорилтот нэг дэлгүүр ногдох хүн амын тоог олон улсын дундаж утга руу 2030 он гэхэд хүргэнэ гэсэн таамаглал (assumption) тавьж үзлээ. Ингэхдээ мөн Монгол улсын хүн амын тоог аймаг болгоноор нь задлан үзэж тооцооллыг боловсруулсан ба аймаг бүрийн нэг дэлгүүрт ногдох хүн амын тоо 6,015, Улаанбаатар хотын хувьд 4,042 байхаар байна. Суурь таамаглалын хувьд зөвхөн Монгол улсын хүн амын өсөлтийг даган дэлгүүрийн тоог нэмэх төсөөллийг мөн боловсрууллаа.

CU-н нэг дэлгүүрт ногдох хүн амын тоо (НДНХА)



МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО
мянган хүн



CU-Н ДЭЛГҮҮРИЙН ТООНЫ ТААМАГЛАЛ: ТЭЛЭЛТИЙН ХУВИЛБАР, АЙМГААР, 2025-2030

Аймаг	2025Н1	2025	2026	2027	2028	2029	2030	НДНХА (2030)
Баян-Өлгий	0	2	7	11	15	17	21	6,012
Говь-Алтай	0	1	3	5	7	9	10	6,034
Завхан	0	2	4	6	9	11	13	5,807
Увс	0	2	5	8	10	13	15	6,043
Ховд	0	2	5	8	11	14	16	6,166
Архангай	6	7	9	11	13	15	16	6,109
Баянхонгор	4	5	8	10	12	14	16	5,873
Булган	4	4	6	7	9	10	11	5,855
Орхон	8	9	12	14	17	18	20	5,972
Өвөрхангай	4	6	9	12	15	18	20	6,103
Хөвсгөл	5	7	11	15	19	21	24	6,068
Говьсүмбэр	2	2	3	3	3	3	3	6,461
Дархан-Уул	6	7	10	13	15	18	20	5,900
Дорноговь	5	5	7	9	10	12	13	5,920
Дундговь	4	4	5	6	7	8	8	6,125
Өмнөговь	6	6	8	10	11	13	14	5,899
Сэлэнгэ	12	12	14	16	17	18	19	5,958
Төв	9	9	11	13	14	15	16	6,108
Дорнод	2	4	6	9	11	13	15	6,021
Сүхбаатар	0	2	4	6	8	10	12	5,852
Хэнтий	5	6	8	10	11	13	14	6,037
Улаанбаатар	413	422	432	440	449	457	467	4,042
Нийт	495	526	587	642	693	740	783	4,833
НДНХА	7,201	6,814	6,172	5,704	5,343	5,058	4,833	

* - Тайлбар: 2030 оны нэг дэлгүүрт ногдох хүн амын тоо нь хүснэгт дээр 4,833 гарсан нь график дээр гарсан 4,831-с 2 хүнээр зөрүүтэй байгаа нь оронгийн нарийвчлал болон ойролцооллын зөрүү юм. Дэлгүүрийн тоо нь натурал тоо тул ойролцоолох үед энэхүү зөрүү үүссэн ба мөн нийт хүн амыг дэлгүүрийн тоонд хуваах үед оронгийн зөрүү үүсч байна.






СУУРЬ ТААМАГЛАЛ


БҮТЭЭМЖИЙН СТРАТЕГИ

Бүтээмжийн стратеги нь дэлгүүрээр үйлчлүүлж буй хүний нэг удаагийн худалдан авалтын дундаж дүнг өсгөх замаар дэлгүүрийн борлуулалтын орлогыг өсгөх стратеги юм. Ирээдүйн таамаглалыг боловсруулахдаа нэг үйлчлүүлэгчийн бодит худалдан авалтын сүүлийн 4 жилийн тренд үргэлжилнэ гэж авч үзсэн бол суурь таамаглалыг боловсруулахад нийт хугацааны дундаж утга хадгалагдана буюу бодит худалдан авалт одоогийн түвшинд байна гэж үзэв. Ингэснээр бүтээмжийн стратегийн хувьд 2030 он гэхэд нэг үйлчлүүлэгчийн бодит худалдан авалт 9,041 MNT (2021H1 суурь) болох ба энэ нь ХҮИ-ийн таамаглалаар нэрлэсэн утга руу хөрвүүлбэл 17,845 MNT болохоор байна.


ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС
2023 = 100



СУ-Н НЭГ ДЭЛГҮҮРТ САРД ҮЙЛЧЛҮҮЛЖ БУЙ НИЙТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОО
сарын дундаж



НЭГ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН БОДИТ ЗАРЦУУЛАЛТ
MNT/хүн, 2021H1 ХҮИ суурь





СУУРЬ ТААМАГЛАЛ

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТААМАГЛАЛ, тэрбум MNT, хагас жилийн цэвэр дүнгээр

Макро таамаглал	Нэгж	2025H1	2025H2	2026H1	2026H2	2027H1	2027H2	2028H1	2028H2	2029H1	2029H2	2030H1	2030H2
Монгол улсын хүн ам	мянган хүн	3,564.4	3,584.0	3,603.5	3,623.0	3,642.5	3,662.0	3,682.5	3,703.0	3,723.0	3,743.0	3,763.5	3,784.0
ХҮИ	2023=100	114.6	119.4	122.1	126.4	127.9	132.6	134.3	139.3	141.0	146.2	148.1	153.5

Суурь хувилбар (Идэвхгүй-Passive)

	Нэгж	2025H1	2025H2	2026H1	2026H2	2027H1	2027H2	2028H1	2028H2	2029H1	2029H2	2030H1	2030H2
Нэг дэлгүүрт ногдох хүн амын тоо	Хүн	7,200.8	7,200.8	7,200.8	7,200.8	7,200.8	7,200.8	7,162.7	7,023.1	6,896.8	6,781.9	6,676.7	6,579.9
Дэлгүүрийн тоо	Нэгж	495.0	498.0	500.0	503.0	506.0	509.0	514.0	527.0	540.0	552.0	564.0	575.0
Нэг дэлгүүрт сард үйлчлүүлж буй үйлчилгээний тоо	Нэгж	11,077.4	10,200.0	10,200.0	10,200.0	10,200.0	10,200.0	10,200.0	10,200.0	10,200.0	10,200.0	10,200.0	10,200.0
Үйлчилгээний тоо	Мянга	32,900.0	30,477.6	30,600.0	30,783.6	30,967.2	31,150.8	31,456.8	32,252.4	33,048.0	33,782.4	34,516.8	35,190.0
Нэг үйлчлүүлэгчийн бодит зарцуулалт	MNT	7,468.3	6,969.0	6,969.0	6,969.0	6,969.0	6,969.0	6,969.0	6,969.0	6,969.0	6,969.0	6,969.0	6,969.0
Бодит борлуулалтын орлого	тэрбум MNT	245.7	212.4	213.3	214.5	215.8	217.1	219.2	224.8	230.3	235.4	240.5	245.2
Борлуулалтын орлого	тэрбум MNT	362.1	326.1	334.7	348.5	354.8	370.1	378.5	402.4	417.5	442.5	457.8	484.0

Үндсэн хувилбар (Бүтээмж + Тэлэлт)

	Нэгж	2025H1	2025H2	2026H1	2026H2	2027H1	2027H2	2028H1	2028H2	2029H1	2029H2	2030H1	2030H2
Нэг дэлгүүрт ногдох хүн амын тоо	Хүн	7,200.8	6,816.0	6,468.7	6,174.7	5,922.8	5,704.4	5,513.4	5,344.8	5,194.9	5,060.8	4,940.2	4,831.0
Дэлгүүрийн тоо	Нэгж	495.0	526.0	557.0	587.0	615.0	642.0	668.0	693.0	717.0	740.0	762.0	783.0
Нэг дэлгүүрт сард үйлчлүүлж буй үйлчилгээний тоо	Нэгж	11,077.4	10,200.0	10,200.0	10,200.0	10,200.0	10,200.0	10,200.0	10,200.0	10,200.0	10,200.0	10,200.0	10,200.0
Үйлчилгээний тоо	Мянга	32,900.0	32,191.2	34,088.4	35,924.4	37,638.0	39,290.4	40,881.6	42,411.6	43,880.4	45,288.0	46,634.4	47,919.6
Нэг үйлчлүүлэгчийн бодит зарцуулалт	MNT	7,468.3	7,612.4	7,755.3	7,898.2	8,041.1	8,183.9	8,326.8	8,469.7	8,612.6	8,755.5	8,898.4	9,041.3
Бодит борлуулалтын орлого	тэрбум MNT	245.7	245.1	264.4	283.7	302.6	321.6	340.4	359.2	377.9	396.5	415.0	433.3
Борлуулалтын орлого	тэрбум MNT	362.1	376.2	415.0	460.9	497.6	548.2	587.7	643.1	685.1	745.3	789.8	855.1

Эх сурвалж: Тооцоолол



МӨНГӨН УРСГАЛЫН ХОРОГДУУЛАЛТЫН ЗАГВАРААР ТООЦСОН ҮНЭЛГЭЭ, тэрбум MNT

Суурь хувилбар (Идэвхгүй-Passive)									
	2024	2025	2026	2027	2028	2029	2030		
Борлуулалтын орлого	598.4	688.2	683.2	724.9	780.8	860.0	941.9	Урт хугацааны өсөлт	5.0%
Өсөлтийн хувь	53.2%	15.0%	-0.7%	6.1%	7.7%	10.1%	9.5%	Урт хугацааны өсөлтийн өнөөгийн үнэ цэн	253.5
Дэлгүүрийн тоо	445.0	498.0	503.0	509.0	527.0	552.0	575.0	Өр	43.4
NOPAT	44.8	53.9	58.4	66.5	76.9	90.7	98.1	Мөнгө	5.8
								WACC	16.5%
								Үнэлгээ	293.0
Чөлөөт МУ-ын өнөөгийн үнэ цэн		7.9	16.8	9.4	7.9	7.2	27.8	Нэгж хувьцаанд ногдох үнэлгээ (MNT)	262.9

Үндсэн хувилбар (Бүтээмж + Тэлэлт)									
	2024	2025	2026	2027	2028	2029	2030		
Борлуулалтын орлого	598.4	738.3	875.8	1,045.8	1,230.7	1,430.4	1,644.9	Урт хугацааны өсөлт	5.0%
Өсөлтийн хувь	53.2%	23.4%	18.6%	19.4%	17.7%	16.2%	15.0%	Урт хугацааны өсөлтийн өнөөгийн үнэ цэн	331.2
Дэлгүүрийн тоо	445.0	526.0	587.0	642.0	693.0	740.0	783.0	Өр	43.4
NOPAT	44.8	57.4	74.2	95.6	120.5	148.4	168.1	Мөнгө	5.8
								WACC	16.5%
								Үнэлгээ	392.9
Чөлөөт МУ-ын өнөөгийн үнэ цэн		8.5	15.9	15.3	13.6	9.6	36.4	Нэгж хувьцаанд ногдох үнэлгээ (MNT)	352.6



ИЖИЛ ТӨСТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ КОМПАНИУДАЙ ХАРЬЦААЛСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН, 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС

Компанийн нэр	Улс	Зах зээлийн үнэлгээ (сая USD)	Бирж:Тэмдэг	EV/EBITDA	P/S	P/E	P/B	ROE%	ROA%
BGF Retail Co,. Ltd	Өмнөд Солонгос	1,206.2	KRX:282330	1.53	0.20	9.04	1.49	16.49%	5.74%
Casey's Retail Company	АНУ	15,350.0	NASDAQ:CASY	15.84	1.03	30.58	0.00	16.65%	7.91%
The Kroger Company	АНУ	44,600.0	NYSE:KR	7.84	0.30	16.74	3.84	22.77%	5.24%
Tesco PLC	Их Британи	67,728.1	LSE:TSCO	7.92	0.77	17.70	2.11	13.94%	4.18%
Carrefour S.A	Франц	9,152.5	Euronext Paris:CA	5.74	0.10	0.01	2.97	5.79%	1.26%
Seven & I Holding Co., Ltd	Япон	35,006.6	TYO:3382	8.21	0.46	14.67	1.30	4.10%	1.52%
GS Retail	Өмнөд Солонгос	940.4	KRX:078930 (Parent)	4.58	0.12	0.66	0.43	0.08%	0.03%
			Хамгийн их	15.84	1.03	30.58	3.84	22.77%	7.91%
			Медиан	7.84	0.30	14.67	1.49	13.94%	4.18%
			Хамгийн бага	1.53	0.10	0.01	0.00	0.08%	0.03%
			Жигнэсэн дундаж	8.48	0.57	16.90	2.24	13.98%	4.08%
Премиум Нэксус ХК	Монгол	67.7	MSE:CUMN	3.74	0.39	2.89	2.78	27.17%	8.90%
			CUMN < W.AVG	Бага	Бага	Бага	Их	Их	Их


* - Тайлбар: 2024 оны 2-р хагас жилээс нэг удаагийн шинж чанартай 19.5 тэрбум төгрөгийн тохиролцоот худалдан авалтын олзыг хасаж тооцов.





ХАНШИЙН АНАЛИЗ

MSE:CUMN ХУВЬЦААНЫ ХАНШ хаалтын ханш, MNT, 2021-11-15 : 2025-08-22



БИЗНЕСИЙН НЭГДЭЛ

“Премиум Нэксус” ХК-ийн бусад бизнесүүдийг нэгтгэн авахдаа зах зээлийн үнээс хямд үнээр худалдан авсан нь орлогын тайлан дээр 19.5 тэрбум төгрөгийн олз хэлбэрээр бүртгэгдсэн билээ. Ийнхүү шинээр нэмж хувьцаа гаргах замаар бизнесүүдийг нэгтгэж, хувьцаа эзэмшигчдийн хувьцааны тоонд өөрчлөлт орохгүйгээр нэгж хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлсэн нь 9,300 хувьцаа эзэмшигчийнхээ хөрөнгийн үнэ цэнийг өсгөсөн гэж үзэж байна.

MSE:CUMN хувьцаа нь 2021 оны 11-р сард анхдагч зах зээл дээр нэгж хувьцаа нь 208 төгрөгийн үнэтэй гарч байсан бөгөөд энэхүү судалгааг хийх үе буюу 2025 оны 8-р сарын 22-ны байдлаар 200 төгрөгт хүрсэн нь -3.8%-ийн уналттай үзүүлэлт юм.

Хоёрдогч зах зээл дээр арилжаа эхэлснээс хойш 934 ажлын өдрийн дундаж трендийг авч үзвэл ханш өсөлтгүй, бууралтгүй тогтмол 175 төгрөгийн орчимд хэлбэлзсэн гэж үзэж болохоор байна. Харин сүүлийн 52 долоо хоногийн дундаж чиг хандлагаар авч үзвэл өсөх тренд ажиглагджээ.

Зарим онцлох хөдөлгөөнүүдээс дурдвал:


- 2022 оны 1-р улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан танилцуулсны дараа 7 хоногийн дотор хувьцааны ханш 15.5%-р (190.4>219.9) өссөн. Тайлангийн онцлог үр дүн нь цэвэр орлого жилийн өмнөх үеэс 246% өссөн явдал байлаа.
- 2022 оны 9-р сарын 30-нд ханш 208 байсан бол 2023 оны 12-р сарын эцсийн байдлаар 148.5 болж энэхүү 1 жил, 1 улирлын хугацаанд -28.6%-р үнэ унасан байна. Энэхүү хугацаанд системийн топ 5 банкнууд анхдагч зах зээл дээр гарсан ба энэ үйл явдал нь богино хугацаанд өндөр дүн бүхий хувьцаа хөрөнгийн зах зээл дээр нийлүүлэгдсэн тул бусад хувьцаануудын ханшийг унагасан юм.
- 2024 оны 1-р улирлын санхүү, үйл ажиллагааны тайлангийн дараа хувьцааны үнэ огцом өсөж 7 хоногийн хугацаанд үнэ 41.5% (135.0>191.0) өсөв. 1-р улирлын тайлангаар 2024 оны 1-р сард болсон бизнесийн нэгтгэлтэй холбоотой өөрчлөлтүүдийг танилцуулсан ба компанийн нийт хөрөнгө жилийн 54.2% өсөлт үзүүлсэн байна.

2025 оны 8-р сарын 22-ны байдлаар MSE:CUMN-ийн зах зээлийн үнэлгээ 222.8 тэрбум төгрөгт хүрсэн бол сүүлийн 52 долоо хоногийн дундаж өдрийн арилжааны хэмжээ 10.3 сая төгрөг байна.

Зах зээлийн үнэлгээ: 222,850,406,800.0 MNT

Өдрийн дундаж арилжаа: 10,278,499.2 MNT

АРИЛЖААНЫ ДҮН, сая MNT



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Үнэт Инновэйшнс







ХАНШИЙН АНАЛИЗ

MSE:CUMN ХУВЬЦААНЫ ХАНШ БА ЦЭВЭР АШИГ

хагас жилийн жигнэсэн дундаж ханш



ХАМААРЛЫН ШИНЖИЛГЭЭ



* - Тайлбар: 2024 оны 2-р хагас жилээс нэг удаагийн шинж чанартай 19.5 тэрбум төгрөгийн тохиролцоот худалдан авалтын олзлыг хасаж тооцов.

Цэвэр ашиг алдагдалтай байсан жилүүдэд компанийн хувьцааны ханш буурч байсан бол, 2024 оноос ашиг эерэг болж эхлэхтэй зэрэгцэн ханш өсөж эхэлсэн нь ашиг болон ханшийн хооронд эерэг хамаарал байж болзошгүйг илтгэж байна. Үзүүлэлтүүдийг графикаар харьцуулан шинжлэхэд мөн ижил чиг хандлагатай буюу эерэг корреляци ажиглагджээ.

Регрессийн үнэлгээнээс дараах үр дүн гарсан байна. Үүнд:

1. Ашиг ба ханшийн зөрүү нь эерэг хамааралтай бөгөөд энэ нь 95%-ийн ач холбогдлын түвшинд статистикийн хувьд ач холбогдолтой байна. Өөрөөр хэлбэл, цэвэр ашиг өндөр байх нь ханшийн өсөлтийг нэмэгдүүлдэг байна.
2. Цэвэр ашиг 751 сая төгрөгөөр өсөх бүрд хувьцааны ханшийн өсөлт 1 төгрөгөөр нэмэгддэг байна.

Гэсэн хэдий ч уг загварын стандарт алдаа 18.1 гарсан нь хэлбэлзэл маш өндөр байгааг харуулж байгаа тул энэхүү үр дүнг ирээдүйн таамаглалд ашиглах нь зохимжгүй юм.

РЕГРЕССИЙН ҮР ДҮН

Хамааран хувьсагч: Ханшийн зөрүү ($\Delta price$)
Үл хамааран хувьсагч: Цэвэр ашиг (profit)

$$\widehat{\Delta price}_t = 0.9069 + 1.3308 \times profit_t$$

[6.8979] + [0.4577]**

$$R^2 = 0.6284 ; N = 7 ; SE = 18.0709$$

Тайлбар: [] – Ст.Хазайлтыг хаалтанд дүрслэв.

* - 10% , ** - 5% , *** - 1% ач холбогдлын түвшинд ач холбогдолтой.






АНХНЫ АМЛАЛТ БА БОДИТ ҮР ДҮН


БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО тэрбум MNT

Дундаж: **112%**




НИЙТ ХӨРӨНГӨ тэрбум MNT

Дундаж: **129%**




ЦЭВЭР АШИГ тэрбум MNT

Дундаж: **-170%**



ДЭЛГҮҮРИЙН ТОО

Дундаж: **109%**



Гүйцэтгэл Үндсэн хувилбар IPO төсөөлөл Гүйцэтгэл %

* - Тайлбар: 2024 оны 2-р хагас жилээс нэг удаагийн шинж чанартай 19.5 тэрбум төгрөгийн тохиролцоот худалдан авалтын олзыг хасаж тооцов.

Эх сурвалж: Үнэт цаасны танилцуулга, үйл ажиллагааны тайлан

2021 онд анхдагч зах зээл дээр гарч байх үед олон нийтэд танилцуулсан үнэт цаасны танилцуулгад тусгагдсан ирээдүйн тоон таамаглалуудын биелэлт харьцангуй сайн гарчээ.

Тухайлбал, борлуулалтын орлогын хувьд 2022 онд 238 тэрбум, 2023 онд 390 тэрбум, 2024 онд 475 тэрбум төгрөгт хүрнэ гэж таамаглаж байсан бол бодит гүйцэтгэлээр 2022 онд 261 тэрбум, 2023 онд 390 тэрбум, 2024 онд 598 тэрбум төгрөг болж, дунджаар 112%-ийн биелэлттэй гарсан байна.

Цэвэр ашгийн хувьд 2022 онд 12.1 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллана гэж төсөөлж байсан ч бодитоор 25.7 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн нь таамагаасаа хоёр дахин өндөр алдагдалтай байв. Мөн 2023 онд 7.7 тэрбум төгрөгийн ашигтай ажиллана гэж тооцоолж байсан ч эсрэгээрээ 32.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ. Харин 2024 онд нөхцөл байдал эрс сайжирч, 22 тэрбум төгрөгийн ашигтай ажиллана гэсэн таамгийг давуулан биелүүлж, 27.9 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь төсөөллөөсөө давсан үзүүлэлт болжээ.

Дэлгүүрийн тооны хувьд урт хугацаанд 360-д хүргэнэ гэж төлөвлөж байсан бол 2023 онд 374, 2024 онд 445 болж, таамгийнхаа дунджаар 109%-ийн гүйцэтгэлтэй гарсан байна.


Нийт хөрөнгийн хэмжээг авч үзвэл, 2024 онд хэд хэдэн бизнесийг нэгтгэсэнтэй холбоотойгоор үлэмж өсөлт гарч, анх 196 тэрбум төгрөгөөр тооцоолж байсан хэмжээг 60%-иар давуулан 314 тэрбум төгрөгт хүрчээ.





ДҮГНЭЛТ

НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН 2025 оны 1-р хагас жил, MNT



Эх сурвалж: Тооцоолол

Конвиниенс дэлгүүрийн зах зээл нь Монгол Улсад харьцангуй шинэ хэдий ч сүүлийн 10 жилийн хугацаанд эрчимтэй хөгжиж буй салбар юм. 2025 оны эхний хагас жилийн байдлаар CU болон GS25 нийлээд нийт 722 салбар дэлгүүртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүний 64%-ийг CU эзэлж байна.

“Премиум Нэксус” ХК нь 2021 оны 11-р сард олон нийтэд нээлттэй компани болсноос хойш 2022 онд “Сиркл Чейн” ХХК-ийн 12 дэлгүүрийг, 2024 онд “Чингис Шар Айраг” ХХК болон “Стора Централ” ХХК зэрэг хэд хэдэн компаниудыг нэгтгэн авч, үйл ажиллагаагаа өргөжүүлсээр байна. Эдгээр үйл явдлууд нь компанийн санхүүгийн үр дүн болон үнэт цаасны ханшид мэдэгдэхүйц нөлөө үзүүлжээ.

CU борлуулалтын орлого тогтвортой өсөж байгаа нь тайлангийн үзүүлэлтүүдээс харагдаж байгаа ба 2025 оны 1-р хагас жилийн байдлаар нийт жижиглэн худалдааны салбарын борлуулалтын орлогын 2.1%-г эзэлж байна. 2024 оноос цэвэр ашиг нь эерэг болж ашигтай ажиллаж эхэлсэн ба 2025 онд ч мөн ашигт ажиллагаа үргэлжилж байна.

Монгол Улсад 4,913 хүн тутамд нэг конвиниенс дэлгүүр ногдож байгаа нь дэлхийн дундажтай ойролцоо үзүүлэлт юм. Энэ нь зах зээлд шинээр нэвтрэх бизнесүүдэд өрсөлдөөн өндөр байгааг илтгэж байна. CU дэлгүүрийн хувьд энэхүү үзүүлэлт нь хот болон аймгуудад ялгаатай байгаа буюу Улаанбаатар хотод 4,281, харин аймгуудад 21,667 хүн тутамд нэг CU дэлгүүр ногдож байна. Тиймээс цаашид аймгуудад дэлгүүр нээх замаар тэлэх боломжтой юм.

Эдгээр зах зээлийн хүчин зүйл дээр үндэслэн “Премиум Нэксус” ХК-ийн үнэлгээг хийхдээ дараах таамаглал (assumption) дээр үндэслэн борлуулалтын орлогыг таамаглав. “Премиум Нэксус” ХК нь нэг дэлгүүрт ногдох хүн амын тоог олон улсын дундаж утгат хүргэх замаар дэлгүүрийн өсөлтийг хадгална. Ингэхдээ аймаг бүрийн хүн амд суурилсан хэлбэрээр салбаруудыг жигд тархаан өсгөнө. Мөн нэг хэрэглэгчийн худалдан авалтын дүнг нэрлэсэн дүнгээр 17.8 мянган төгрөгт хүргэх замаар үр ашигт байдлыг сайжруулж борлуулалтын орлогоо нэмэгдүүлнэ.

Эдгээр стратегийг хэрэгжүүлснээр борлуулалтын орлогын өсөлтийг 15%-д барих ба цэвэр ашгаас бий болох мөнгөн урсгалыг хорогдуулах замаар үнэлгээг тооцоолон үзлээ. Үр дүнд компанийн үнэлгээ 392.9 тэрбум төгрөг, нэгж хувьцаанд ногдох үнэлгээ нь 352.6 төгрөг байна. Зах зээлийн үнэлгээ нь 2025 оны 6-р сарын байдлаар 207.7 төгрөг байгаа нь тус компанийн хувьцаа хямдхан үнэлэгдэж байгааг илтгэж байна. Олон улсын бусад конвиниенс болон сүлжээ дэлгүүрүүдийн бизнестэй харьцуулан үзэхэд мөн үнэлгээний үр дүнг дэмжиж байна.

“Премиум Нэксус” ХК-ийн хувьд анх 2021 онд олон нийтэд танилцуулж байсан үнэт цаасны танилцуулга дээрх санхүүгийн гүйцэтгэлдээ борлуулалтын орлого, дэлгүүрийн тоо, нийт хөрөнгийн үзүүлэлтүүд дээр амлалтдаа хүрсэн харагдаж байна. Мөн цэвэр ашгийн хувьд 2024 оноос эхлэн таамаглалдаа хүрч эхэлжээ.





ҮНЭТ Секьюритис ҮЦК

Энэхүү үнэт цаасны судалгааны ажил нь “Үнэт Секьюритис ҮЦК” ХХК-ийн оюуны өмч бөгөөд тус компанийн урьдчилан бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр тайлангийн аливаа хэсгийг хуулбарлах, түгээх, дамжуулах, өөрчлөх, дэд эрх олгох болон дахин борлуулахыг хатуу хориглоно.

Энэхүү судалгааны ажил нь тухайн цаг хугацаанд олон нийтэд нээлттэй байгаа тоон мэдээлэлд тулгуурлан боловсруулсан бөгөөд тайланд тусгагдсан агуулга, үзэл бодол, дүгнэлт нь заавал “Үнэт Секьюритис ҮЦК” ХХК-ийн албан ёсны байр суурийг илэрхийлэх албагүй болно.

Энэхүү судалгаанд багтсан мэдээлэл, тоон үзүүлэлт болон дүгнэлт нь зөвхөн судалгааны болон мэдээллийн зорилготой болно. Энэ нь үнэт цаас худалдан авах, зарах эсвэл арилжаалах талаарх зөвлөмж, шийдвэр гаргах үндэслэл биш юм. Үнэт цаасны зах зээл нь эрсдэлтэй бөгөөд аливаа хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргахдаа тухайн эрсдэлийг өөрөө бүрэн хариуцна. Энэхүү судалгааны мэдээллийг ашигласнаас үүдэн гарах аливаа санхүүгийн хохирол, эрсдэлд “Үнэт Секьюритис ҮЦК” ХХК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй болно.



(+976) 7700-9090



usecurities@unet.mn



<https://unetsecurities.mn>



**Эко Интернэшнл Тауэр,
СБД, 1-р хороо,
Энхтайвны өргөн чөлөө
Улаанбаатар хот, Монгол улс**

